



Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн
Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл
мэндийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн
тухай, Зөрчлийн тухай хуулиудад Өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн

ЗАРДЛЫН ТООЦОО

ЗАХИАЛАГЧ:

УИХ-ын гишүүн Х.Ганхуяг

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Өмгөөллийн “Соёмбо Легал Партнерс” ХХН

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Д.Алтансүх	Өмгөөллийн “Соёмбо Легал Партнерс” ХХН-ийн Ахлах хуульч, өмгөөлөгч
С.Ундрал	Өмгөөллийн “Соёмбо Легал Партнерс” ХХН-ийн Хуульч, өмгөөлөгч

Энэхүү тайланг Өмгөөллийн “Соёмбо Легал Партнерс” ХХН нь УИХ-ын гишүүн Х.Ганхуягийн захиалгаар боловсруулсан бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт нь Захиалагчийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

ӨМГӨӨЛЛИЙН “СОЁМБО ЛЕГАЛ ПАРТНЕРС” ХХН
Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
51-р байр, 2 давхар
Утас: 77110425, 70110425
Цахим шуудан: info@mongolianlawyer.mn
Цахим хуудас: <http://mongolianlawyer.mn>

НЭГ. УДИРТГАЛ

2024 оны 03 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэв.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйл (Тусгай зөвшөөрлийн жагсаалт)-ийн 13.16 дах заалт “БИБ-ийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоно” гэж заасныг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Үүнтэй холбогдуулж салбар дундын харилцааг зохицуулж буй Зөвшөөрлийн тухай хуульд орсон өөрчлөлтөд салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор дор дурдсан хуулиудад өөрчлөлт оруулахтай холбогдон гарах зардлыг нэгдсэн байдлаар тооцсон болно. Үүнд:

1. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
3. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Судалгааны хамрах хүрээ:

Хуулийн төсөл нь иргэн, аж ахуйн нэгжид шууд болон шууд бус байдлаар заавал биелүүлэх шинжтэй үүрэг ногдуулсан зохицуулалт агуулаагүй тул зардал үүсгэхгүй гэж дүгнэв.

Иймд энэхүү судалгааг зөвхөн төрийн байгууллагад үүсэх зардал буюу хүний нөөцийн ачааллыг тооцох замаар хийж гүйцэтгэсэн болно.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Хувилбарыг нягтлан дүгнэх.

2.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Судалгааны энэ хэсэгт хуулийн төсөлд заагдсан үүрэг хүлээж буй төрийн байгууллагуудад шинээр бий болгож буй үүргүүдийг нэг бүрчлэн тодорхойлох шаардлагатай байдаг.

Өргөн барьж буй хуулийн төслийн хувьд иргэн, аж ахуйн нэгжүүд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг байсан Зөвшөөрлийн тухай хуулийн зохицуулалт хүчингүй болсонтой холбогдуулж салбарын бусад хуулиудын түүнд нийцүүлэх, хийдэл, зөрчлийг арилгах зорилготой болно.

Өөрөөр хэлбэл хуулийн төсөл нь төрийн байгууллагуудад шинээр үүрэг бий болгоогүй, харин иргэн, аж ахуйн нэгжүүдээс тусгай зөвшөөрөл шаардах эрх зүйн үндэслэлийг хуулиас хасах буюу хүчингүй болгох зохицуулалт агуулж байна.

2.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Дээр дурдсанчлан хуулийн төсөл нь биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хийх төрийн байгууллагуудын үүргийг хуулиас хасаж, хүчингүй болгосон тул үүнтэй холбоотойгоор хүний нөөцөд аливаа ачаалал үүсэхээргүй байна.

Өөрөөр хэлбэл хуулийн төсөлтэй холбогдуулж орон тоо нэмэгдүүлэх шаардлага байхгүй байна.

2.3. Хүний нөөцтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох

Зардлын тооцоо нь хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлуудын нийлбэрээс бүрддэг.

Өмнөх үе шатанд хуулийн төсөлтэй холбоотойгор төрийн байгууллагууд хүний нөөцийн орон тоогоо нэмэгдүүлэх шаардлага байхгүй гэж үзсэн ба биологийн идэвхит бүтээгдэхүүнд тусгай зөвшөөрөл өгөх эсхүл бүртгэл хийх шаардлагагүй болсон талаар мэдээлэл өгөх нь холбогдох байгууллагуудын чиг үүрэгт хамаарах тул аливаа зардал гарахгүй.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Өмнөтгөл хэсэгт дурдсаны дагуу хуулийн төслийн зардлын тооцоог (1) Иргэн, (2) Хуулийн этгээд, (3) Төрийн байгууллагад үүсэх зардал гэж ялгамжтай байдлаар тооцон үздэг.

Судалгаагаар авч үзсэн Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад зардал үүсгэх хэмжээний үүрэг болгосон заалт агуулаагүй тул хүний нөөцийн болон бусад зардал гарахгүй гэж үзсэн.

Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа зардал гарахгүй байх тул хуулийн төслийн үр өгөөж, зардлын харьцаа өндөр байна.

--- о 0 о ---